

ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.3, 3.2.9, 3.7.9 дэх зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 7, 33 дугаар зүйлийн 3, Орон сууцны тухай хуулийн 6.1.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Иргэдийн орон сууцжуулалтыг нэмэгдүүлэх, хуримтлалын нэгдсэн сан, Үндэсний баялгийн санг бүрдүүлэх, дундаж давхаргыг тэлэх үндэсний хорооны бүрэлдэхүүн"-ийг "Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай" Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 27 дугаар тогтоолын 33 дугаар хавсралт болгон хавсралт ёсоор баталсугай.
2. Үндэсний хорооны ажиллах журмыг баталж мөрдүүлэхийг Үндэсний хороо (Л.Оюун-Эрдэнэ)-нд, зайлшгүй шаардлагатай асуудлаар Ажлын дэд хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулж ажиллуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдоржид тус тус даалгасугай.
3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдоржид даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Монгол Улсын сайд,Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.НЯМДОРЖ